

НЬЮ-БАЛАНС АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дүгээр Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/211/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Мөрөн сум 2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 цахим хаяг: teqshdelgerb@audit.gov.mn
Нью-баланс аудит ХХК-ний партнер Б.Лхагвадорж
Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com
Аудитор: Л.Наранбаатар
Утас: 99509636 Цахим хаяг: naraa_9636@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/202
танай _____-ны № _____-т

МӨРӨН СУМЫН 8 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГ ЭРХЛЭГЧ
Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мөрөн сумын 8 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөрөн сумын 8 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба улсын төсвөөс 498,478.6 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 16,640.4 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 81,836.4 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 97,792.0 мянган төгрөгийн залруулгыг хийж, төсвийг зохистой удирдаж ажиллаагүйгээс 2,831.5 мянган төгрөгийн авлага, 951.0 мянган төгрөгийн өр үүсгэсэн, эдийн засгийн ангилал зөрчиж 929.4 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн, хүүхдийн хоолны норм баримтлаагүйгээс 1,245.1 мянган төгрөгийн зардлыг хэтрүүлсэн зэрэг зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хангалттай биелүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй

баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А. ЭРДЭНЭБААТАР

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	529,954,836.99	611,162,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	483,856,536.99	30,847,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	22,138,936.99	30,847,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,138,936.99	30,847,700.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	3,500,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	18,638,936.99	30,847,700.00
122	Тусламжийн орлого	1,882,500.00	00.00
122001	Хандив тусламж /дотоод/	1,882,500.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	459,835,100.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	459,835,100.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	46,098,300.00	580,315,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	498,478,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	498,478,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,911,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,875,200.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,860,800.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	175,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,187,300.00	81,836,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,187,300.00	81,836,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	498,738,529.52	594,790,868.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	498,738,529.52	594,790,868.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	498,407,861.05	594,790,845.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	330,481,700.00	376,726,396.72
210101	Үндсэн цалин	205,449,635.94	261,624,817.61
210102	Нэмэгдэл	98,080,076.25	93,589,719.76
210104	Урамшуулал	26,951,987.81	21,511,859.35
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,459,036.78	56,250,800.00
210201	Тэтгэврийн даатгал	31,239,736.78	38,169,838.71
210202	Тэтгэмжийн даатгал	3,304,800.00	4,753,439.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,643,900.00	3,727,810.81
210204	Ажилгүйдлийн даатгал	660,900.00	1,296,115.07
210205	Эрүүл мэндийн даатгал	6,609,700.00	8,303,596.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	31,445,621.25	35,078,999.68
210301	Гэрэл, цахилгаан	1,749,717.00	4,836,093.68
210302	Түлш, халаалт	25,613,123.00	26,944,906.00
210303	Цэвэр, бохир ус	4,082,781.25	3,298,000.00

2104	Хангамж, бараа материалын зардал	7,719,800.00	7,256,150.00
210401	Бичиг хэрэг	489,900.00	2,334,500.00
210402	Тээвэр, шатахуун	350,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	1,677,100.00	348,000.00
210404	Ном, хэвлэл	262,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,741,800.00	603,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,198,700.00	3,970,650.00
2105	Нормативт зардал	19,016,211.90	53,443,530.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	229,900.00	00.00
210502	Хоол, хүнс	17,737,111.90	53,443,530.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,049,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,549,500.00	23,096,800.00
210604	Урсгал засвар	8,549,500.00	23,096,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,249,000.00	962,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,529,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	962,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47,486,991.12	41,976,168.88
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,396,984.16	3,976,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,196,700.00	401,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,893,306.96	37,599,168.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	330,668.47	22.84
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	91,327.75	22.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,327.75	22.84
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	239,340.72	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	239,340.72	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>31,216,307.47</u>	<u>16,371,831.68</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,644,100.00	30,936,564.54
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,644,100.00	30,936,564.54
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,644,100.00	-30,936,564.54
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>28,572,207.47</u>	<u>-14,564,732.86</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>511,433,400.00</u>	<u>580,315,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	463,335,100.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,500,000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,500,000.00	00.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	3,500,000.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	459,835,100.00	00.00

123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	459,835,100.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	48,098,300.00	580,315,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	498,478,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	498,478,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,911,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,875,200.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,860,800.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,175,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	39,187,300.00	81,836,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,187,300.00	81,836,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>477,773,400.00</u>	<u>563,674,620.09</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	477,773,400.00	563,674,620.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	477,442,731.53	563,674,597.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	330,481,700.00	379,557,915.57
210101	Үндсэн цалин	205,449,635.94	264,956,363.37
210102	Нэмэгдэл	98,080,076.25	97,893,391.91
210104	Урамшуулал	26,951,987.81	16,708,160.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,459,036.78	56,250,800.00
210201	Тэтгэврийн даатгал	31,239,736.78	38,600,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,304,800.00	4,415,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,643,900.00	3,524,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	660,900.00	950,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,609,700.00	8,760,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,949,672.25	36,178,999.68
210301	Гэрэл, цахилгаан	1,749,717.00	3,174,129.68
210302	Түлш, халаалт	22,117,174.00	29,706,870.00
210303	Цэвэр, бохир ус	4,082,781.25	3,298,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,719,800.00	00.00
210401	Бичиг хэрэг	489,900.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	350,000.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,677,100.00	00.00
210404	Ном, хэвлэл	262,300.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	2,741,800.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,198,700.00	00.00
2105	Нормативт зардал	21,620,622.50	55,247,682.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	154,900.00	00.00
210502	Хоол, хүнс	20,416,522.50	55,247,682.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,049,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,936,300.00	23,000,000.00
210602	Тавилга	3,290,000.00	00.00
210604	Урсгал засвар	14,646,300.00	23,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	13,743,000.00	962,000.00

	төлбөр, хураамж		
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,023,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	962,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,532,600.00	12,477,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,335,900.00	9,777,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,196,700.00	2,700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	330,668.47	22.84
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	91,327.75	22.84
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	91,327.75	22.84
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	239,340.72	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	239,340.72	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>33,660,000.00</u>	<u>16,640,379.91</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,660,000.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,660,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,660,000.00	00.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,660,000.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-33,660,000.00</u>	<u>00.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,268,022.00	310,217,359.43	17,993,667.16	546,479,048.59
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,268,022.00	310,217,359.43	29,268,134.44	557,753,515.87
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-14,564,732.86	-14,564,732.86
D09	2012 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	218,268,022.00	310,217,359.43	14,703,401.58	543,188,783.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	580,315,000.00	563,674,597.25	16,640,402.75	97.13
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН				

		580,315,000.00	563,674,597.25	16,640,402.75	97.13
210	Бараа, үйлчилгээний зардал	580,315,000.00	563,674,597.25	16,640,402.75	97.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	391,615,900.00	379,557,915.57	12,057,984.43	96.92
210101	Үндсэн цалин	320,711,200.00	264,956,363.37	55,754,836.63	82.62
210102	Нэмэгдэл	63,367,100.00	97,893,391.91	(34,526,291.91)	154.49
210104	Урамшуулал	7,537,600.00	16,708,160.29	(9,170,560.29)	221.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,257,400.00	56,250,800.00	6,600.00	99.99
210201	Тэтгэврийн даатгал	38,600,300.00	38,600,300.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,415,000.00	4,415,000.00	-	100.00
210203	ҮОМШӨ ний даатгал	3,531,000.00	3,524,400.00	6,600.00	99.81
210204	Ажилгүйдлийн даатгал	882,700.00	950,200.00	(67,500.00)	107.65
210205	Эрүүл мэндийн даатгал	8,828,400.00	8,760,900.00	67,500.00	99.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,179,000.00	36,178,999.68	0.32	100.00
210301	Гэрэл цахилгаан	2,899,300.00	3,174,129.68	(274,829.68)	109.48
210302	Түлш, халаалт	29,858,200.00	29,706,870.00	151,330.00	99.49
210303	Цэвэр, бохир ус	3,421,500.00	3,298,000.00	123,500.00	96.39
2105	Нормативт зардал	59,811,500.00	55,247,682.00	4,563,818.00	92.37
210502	Хоол, хүнс	59,811,500.00	55,247,682.00	4,563,818.00	92.37
2106	Эд хогшил худалдан авах	23,000,000.00	23,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	23,000,000.00	23,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	962,000.00	962,000.00	-	100.00
210806	Мэдээллийн технологийн зардал	962,000.00	962,000.00	-	100.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	12,489,200.00	12,477,200.00	12,000.00	99.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,789,200.00	9,777,200.00	12,000.00	99.88
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,700,000.00	2,700,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	580,315,000.00	580,314,977.16	22.84	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	498,478,600.00	498,478,600.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	498,478,600.00	498,478,600.00	-	100.00

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	81,836,400.00	81,836,377.16	22.84	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	81,836,400.00	81,836,377.16	22.84	100.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	16,640,379.91	(16,640,379.91)	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	27.00	27.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй байна.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар: Мөрөн сумын 8 дугаар цэцэрлэг нь тухайн орон нутагт сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг эрхэлж байна.

Тус хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд “Баг хамт олны сайн туршлага, хамтын хөгжлийг дэмжиж үнэлгээнд суурилсан гүйцэтгэлийг хэрэгжүүлнэ” гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ.
2. Хүүхэд бүрийн бүтээлч үйлээрээ хөгжих боломжийг дэмжинэ.
3. Хүүхэд-багш, эцэг эх хамтын ажиллагааг сайжруулна.
4. Багш ажилчдын мэргэжлийн бүлгээр хамтран ажиллана

Хүүхдийн цэцэрлэгийн захирал нь Мөрөн сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө хийж, түүнийг 85 хувь биелүүлж ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар: 2022 онд боловсролын салбарт шинэчлэл хийж, түүнийг дэмжсэн төсвийг батлан хэрэгжүүлэхийг зорьсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Боловсролын салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын яамнаас гаргаж мөрдүүлсэн байна. Тухайлбал:
 - Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулсан ба 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан байна.
 - Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчдад хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн”, “Төрийн болон орон нутгийн өмчит цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хэв шинж, хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүр”, “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” баталсан байна.

- БШУС-ын 2022 оны А/122 дугаар тушаалаар Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолыг үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоосон.
- БШУС-ын 2022 оны А/170 дүгээр тушаалаар “төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх хуваарилах заавар”-ыг 1 дүгээр, “багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”-ыг 2 дугаар, “цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг 3 дугаар, “тоног төхөөрөмжийн нөхөн хангалтын зардлыг төлөвлөх хуваарилах, санхүүжүүлэх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/259 дүгээр тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын багшийг эрүүл мэндийн нэмэлт үзлэг, оношилгоонд хамруулах заавар”-ыг баталсан байна.
- БШУС-ын 2022 оны А/430 дугаар тушаалаар багшийн ажлыг үнэлэх журмыг шинэчлэн баталсан.
- БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллын зардлыг санхүүжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 12 сарын 03 өдрийн А/08 тоот тушаалаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд хийсэн шалгалтаар дараах зөрчил илрүүлж дараах зөвлөмжийг өгч ажилласан байна. Үүнд:

- Гадна тоглоомын талбайн аюулгүй байдлыг бүрэн хангах,
- Тэмдэг тэмдэглэгээг байршуулах,
- Өнгө үзэмжийг сайжруулах,
- Цэцэрлэгийн барилга доторх тог цахилгаан, гэрэлтүүлгийн аюулгүй байдлыг бүрэн хангах,
- Гал тогооны 3 дамжлагат угаалтуурын ус дамждаг хоолойд таг хийх, том хүний болон ангиудын 00-ын бочкыг янзалж цэвэр бохир усны хэрэглээг хэмнэх,
- Гал тогооны 380кв-ын цахилгааны эх үүсгэврийг хамгаалалтын хайрцагтай болгох

Дээрх зөвлөмжүүдийг тогтоосон хугацаанд хэрэгжүүлсэн байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын 8 дүгээр цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсролын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Боловсролын яам, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөрөн сумын 8 дүгээр цэцэрлэгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,985.1 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.0	16,640.4	-16,640.4
Авлага	00.00	2,831.52	-2,831.5
Бараа материал	85,089.2	91,459.5	-6,370.3
Үндсэн хөрөнгө	472,664.3	433,208.3	39,456.0
Нийт хөрөнгө	557,753.5	544,139.8	13,613.7
Өр төлбөр	00.0	951.0	-951.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	218,268.0	218,268.0	0.0
Хуримтлагдсан үр дүн	29,268.1	14,703.4	14,564.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	310,217.4	310,217.4	0.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	557,753.5	544,139.8	13,613.7

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал данс өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 16,640.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 8,999.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хүүхдийн хоолны материалын үлдэгдэл гол нөлөөг үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 648,100.0 мянган, орон нутгийн төсвөөс, 126,900.0 мянган, төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтээр санхүүжүүлэх дүнг 332,900.0 мянган төгрөгөөр бууруулж, 315,200.0 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөр санхүүжүүлэх дүнг 126,900.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 3 дугаар сарын 24-ны А/105 тоот тушаалаар баталж ирүүлсэн ба Боловсрол Шинжлэх ухааны сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны А/392 тоот тушаалаар төсвийн сар, улирлын хуваарь өөрчлөлт оруулсан байна. Тус өөрчлөлтөөр анх баталсан төсвийг 183,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. 2022 оны 5-р сараас үйлчилгээний албан хаагчдын цалинг улсын төсөв рүү шилжүүлсэн тул 45,1 сая төгрөгөөр бууруулж, 81,8 сая төгрөгөөр дахин тодотгосон байна.

Боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог бий болгож, 2022 оноос санхүүгийн хувь хагас бие даалгаж, үр дүн, чанар гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлэх, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлын санхүүжилт, суралцагчийн сургалтын чанарыг үнэлэх хараат бус тогтолцоо, багшийн ажлын үр дүнг сургалцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого зэргийг багцаар нь шийдвэрлэхээр хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулж, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ч үр дүнд суурилсан байдлаар хэрэгжүүлэхийг зорьсон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны улсын төсвөөс санхүүжих дүнг 183,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсвийг 45,100.0 мянган төгрөгөөр бууруулж, 81,836.4 мянган төгрөгөөр тус тус тодотгосон байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 498,478.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 81,836.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 498,478.6 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч батлагдсан төсвийн дагуу зарцуулж, 16,640.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 81,836.4 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 0.002 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 563,674.5 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг цалингийн зардлаас 12.0 сая, хүүхдийн хоолны 4.5 сая, төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Хүүхдийн хоол	59,811.50	55,247.60	4,563.90	92.4
2	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,300.00	1,288.00	12.00	99.1
3	Эрүүл мэндийн үйлчилгээ	1,300.00	1,300.00	-	100.0
4	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,909.20	1,909.20	-	100.0

5	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө	373,978.70	362,324.80	11,653.90	96.9
6	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	60,359.20	59,768.70	590.50	99.0
7	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	59,178.90	59,178.90	-	100.0
8	Нийтлэг үйлчилгээ	22,657.30	22,657.30	-	100.0
	Нийт	580,494.80	563,674.50	16,820.30	97.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр санхүүжсэн хөтөлбөр, арга хэмжээ байхгүй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөрөн сумын 8 дүгээр цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс аудит ХХК-ний ахлах аудитор П.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг Ньюбаланс аудит ХХК-ийн захирал Б.Лхагвадорж анхан шатанд хянаж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Мөрөн сумын 8 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нью-баланс аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 498,738.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 7,979.8 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно. Тус байгууллагад дэд болон орлогч даргын орон тоо бүтэц, орон тоонд нь батлагдаагүй, албан тушаалын автомашин байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мөрөн сумын 8 дүгээр цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад зарлагын 32,514.1 мянган төгрөгийн 5 гүйлгээ, орлогын 21,490.9 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, орлогын 48,814.8 мянган төгрөгийн 3 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
2. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан 63,500.0 мянган төгрөгийн арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг журамд заасан шаардлагын дагуу мэдээлээгүй, тендерт шалгарсан оролцогчийн товч мэдээлэл оруулаагүй байна.
3. Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын хавсралтаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө оруулаагүй

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх насны боловсролын тухай хуулийн холбогдох заалт, 2022 онд шинээр хэрэгжиж эхэлсэн журам заавруудын хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчилтэй асуудал илэрч байна. Үүнд:

1. Хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан норм, нормативын дагуу тооцож олгосон эсэхийг дахин хянахад 2022 онд 1,245.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрч байна. Энэ нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.11 дэх заалттай нийцэхүй байгаа бөгөөд “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлсэн

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Мөрөн сумын 8 дүгээр цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар 1 зөвлөмжийг хүргүүлснийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0.0	0	0	0
Нийт дүн	1	0.0	0	0	0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 270,128.7 мянган төгрөгийн алдаа ,зөрчил¹ илрүүлж, аудитын хугацаанд 97,792.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, дахин давтахгүй байх 4 зөвлөмж өгсөн.

5.1 Аудитаар хийсэн залруулга

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой дараах залруулгыг хийсэн болно.

Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдаж авсан дүн Мөнгөн гүйлгээний тайлангийн биет болон биет бус хөрөнгө худалдан авсан зардлын дүнгээс 12,759.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байсныг залруулсан
- Санхүүгийн байдлын тайлангаарх авлагын эцсийн үлдэгдлийн дүн авлагын тодруулгын дүнтэй 2,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байсныг залруулсан.
- Санхүүгийн байдлын тайлангаарх бараа материалын эцсийн үлдэгдлийн дүнг Бараа материалын тодруулгын тайлантай 1,195.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байсныг залруулсан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд орон нутгийн төсвөөр санхүүжих дүн 81,836.4 мянган төгрөгийг орхигдуулсныг залруулсан

5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

Мөрөн сумын 8 дүгээр цэцэрлэгийн 2022 оны шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавьсан мэдээллийг хянаж үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад зарлагын 32,514.1 мянган төгрөгийн 5 гүйлгээ, орлогын 21,490.9 мянган төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, орлогын 48,814.8 мянган төгрөгийн 3 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
2. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан 63,500.0 мянган төгрөгийн арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллийг журамд заасан шаардлагын дагуу мэдээлээгүй, тендерт шалгарсан оролцогчийн товч мэдээлэл оруулаагүй байна.
3. Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын хавсралтаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө оруулаагүй

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Батлагдсан төсвийг хүрээнд зардал гараагүй ба тайланд онд ажиллагсадтай холбоотой авлага 2,831.5 мянган төгрөг, 951.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах

2. Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор баталсан норм, нормативын дагуу тооцож олгосон эсэхийг дахин хянахад 2022 онд 1,245.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан зөрчил илэрч байна. Энэ нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.11 дэх заалттай нийцэхгүй байгаа бөгөөд “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хүүхдийн хоолны норм, нормативыг баримтлан ажиллах

3. Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүүхдийн хоолны материалын зарцуулалтыг нягтлан бодох бүртгэлд бүртгэхдээ өдөр бүр материалын зарцуулалтыг хийдэггүй, сарын эцэст нэг удаа хийсэн, материалыг бөөн дүнгээр зарцуулсан, 5 сард 22 өдөр ажиллаж 2910 хүүхэд авсан боловч Ерөнхий журналд зардал бичигдээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасныг зөрчсөн ба “үнэн зөв” гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллах

4. Эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал

Илрүүлэлт

Цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлаас ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 929.4 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан зааврыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрүүтэй тайлагнасан	4	97,792.0	0	0	4	97,792.0	4	97,792.0	0	0	0	0
Дүн	4	97,792.0	0	0	4	97,792.0	4	97,792.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өр, авлага үүсгэсэн	1	3,782.5					1	3,782.5			0	0
Эдийн засгийн ангилал зөрчсөн	1	929.4					1	929.4				
Нягтлан бодох бүртгэлээр тавих дотоод хяналт алдагдсан	1	0					1	0				
Дүн	3	4,711.9					3	4,711.9	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлээгүй	7	117,505.0			7	117,505.0		
Хугацаа хоцроосон	3	48,814.8			3	48,814.8		
Дүн	10	166,319.8			10	166,319.8		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Норм норматив зөрчсөн	1	1,245.1					1	1,245.1
Дүн	1	1,245.1					1	1,245.1
Нийт дүн	11	167,564.9			10	166,319.8	1	1,245.1

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:
 АУДИТЫН МЕНЕЖЕР
 АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: *Б/24*

Л.МАНДАХНАРАН ОГНОО: *11/24*

БЭЛТГЭСЭН:
 НЬУ БАЛАНС АУДИТ ХХК-ИЙН
 ЗАХИРАЛ

Б.ЛХАГВАДОРЖ ОГНОО: *2023.02.23*



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 02 өдөр

№ 13/АЭЭБ0439/ХӨА-2023/009/11А
- СТА-7ШЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мөрөн сумын Хүүхдийн 8-р цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын 2 гүйлгээг мэдээлээгүй 102,819,712.00 (нэг зуун хоёр сая найман зуун арван есөн мянга долоон зуун арван хоёр) төгрөг, тендерт шалгарсан оролцогчийн товч мэдээлэл байхгүй 63,500,000.00(жаран гурван сая таван зуун мянга) нийт 166,319,712.00(нэг зуун жаран зургаан сая гурван зуун арван есөн мянга долоон зуун арван хоёр) төгрөгийн зөрчил гаргасан байна.
2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр; 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй”, 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно” гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 9 дугаар сарын 01-ний дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын Хүүхдийн 8-р цэцэрлэгийн эрхлэгч Б.Эрдэнэцэцэг, нягтлан бодогч О.Цэвэлсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:  Б.ЛХАГВАДОРЖ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043